



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/664

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а" дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 65 дугаар зүйлийн 65.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүрэнхаан сургууль, цэцэрлэгийн цогцолборыг цэцэрлэгийн зориулалттай болгож засварлах засварын ажлын зураг, төсөл боловсруулахад 10000000 /арван сая/, Мөрөн сумын орон сууцны байруудын гадна фасадны засварын ажлын зураг, төсөл боловсруулахад 8000000 /найман сая/, Мөрөн сумын 1, 4, 6, 7 дугаар багийн гэрэлтүүлгийн ажлын зураг, төсөл боловсруулахад 30000000 /гучин сая/, нийт 48000000 /дөчин найман сая/ төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сан дахь Зураг төсвийн сангаас зарцуулсугай.
2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын төсөл арга хэмжээний зураг төсөв боловсруулах зөвлөхийг хуулийн дагуу сонгож, гэрээ байгуулахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Болд/-д даалгасугай.
3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД